



**МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2007 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 65

Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 14.2.16 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага, түүний биелэлтэд хяналт тавих тухай журам”-ыг хавсралтаар баталж, 2007 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /О.Ганбат/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

**ДААТГАГЧИЙН ДАВХАР ДААТГАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД  
ТАВИГДАХ ШААРДЛАГА, ТҮҮНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ  
ТАВИХ ТУХАЙ ЖУРАМ**

**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

1.1. Энэ журмын зорилго нь Монгол Улсын Даатгалын тухай хуулийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл бүхий даатгагчийн давхар даатгуулах үйл ажиллагаанд хяналт тавих, даатгагч үйл ажиллагааны эрсдэлээ бууруулах зорилгоор давхар даатгалын арга хэрэгслийг ашиглах, давхар даатгалын төлөвлөгөө гаргах, түүний биелэлтэд хяналт тавихтай холбоотойгоор үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Даатгалын компани нь эрсдэлээ зөвхөн дотоодын эсвэл гадаадын аль нэг улсын эрх бүхий байгууллагаас олгосон (гаднаас давхар даатгал авах) давхар даатгалын болон давхар даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий компанид давхар даатгуулах буюу давхар даатгалаа зуучлуулна.

**ХОЁР. НЭР ТОМЬЁО**

2.1. Энэ журамд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. Факультатив (facultative) давхар даатгал гэдэгт даатгагч, давхар даатгагч нар нь анхны гэрээ нэг бүрээр хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр хийгдэх хэлцлийг;

2.1.2. Гэрээт (treaty) давхар даатгал гэдэгт гэрээнд заасан тодорхой хязгаарын хүрээнд даатгагчаас санал болгон шилжүүлсэн давхар даатгалыг давхар даатгагч шууд хүлээн авахаар зөвшилцсөн хэлцлийг;

2.1.3. Даатгалын слип (slip) гэдэгт давхар даатгалын гэрээний хавсралт буюу давхар даатгалын компани даатгалын эрсдлийг хүлээн авсныг баталгаажуулж гаргасан баримтыг;

2.1.4. Даатгалын ковер нот (cover note) гэдэгт даатгалын брокероос даатгагчид ирүүлсэн даатгал хийгдсэнийг гэрчилсэн баримтыг.

**ГУРАВ. ДАВХАР ДААТГАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ,  
ТҮҮНД ТАВИХ ШААРДЛАГА**

3.1. Даатгалын компани нь Даатгалын тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу даатгалын эрсдэлийг хариуцах үүргээ давхар даатгуулах төлөвлөгөөтэй байна. Давхар даатгалын төлөвлөгөөг тухайн даатгалын компанийн бизнес төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, төлөөлөн удирдах зөвлөл (цаашид ТУЗ гэх) эсвэл түүнтэй адил эрх бүхий этгээдээс баталж гаргана.

3.2. Даатгалын компанийн төлөвлөгөө нь давхар даатгалын стратеги төлөвлөгөө, жилийн төлөвлөгөөнөөс бүрдэнэ.

3.3. Давхар даатгалын стратеги төлөвлөгөө нь тухайн даатгагчийн давхар даатгалын бодлогоо тодорхойлох үндсэн баримт бичиг болох ба үүнд дараах зүйлсийг тусгана:

3.3.1. Тухайн даатгалын компанийн хүлээж чадах нийт эрсдэлийн хэмжээг тодорхойлох, удирдах талаар;

3.3.2. Давхар даатгагчийг сонгох, түүний үйл ажиллагааны хэвийн байдлын талаар дүгнэлт гаргах талаар;

3.3.3. Шаардлагатай тохиолдолд давхар даатгагчаас нөхөн төлбөр төлөх баталгаат байдлыг тодорхойлох талаар;

3.3.4. Давхар даатгалын хяналт, тайлагнал, дотоод хяналтын талаар авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар;

3.3.5. Давхар даатгалын нөхөн төлбөр болон хохирлын нөхөн төлбөрийг төлөх явц нь цаг хугацааны хувьд зохицохгүй байх нөхцөлд бэлэн мөнгөний урсгалыг зохицуулах талаар;

3.3.6. Факультатив эсвэл бусад давхар даатгалд хамрагдах шалгуур үзүүлэлтийн талаар;

3.3.7. Хамтарч ажиллах давхар даатгагч, давхар даатгалын зуучлагчийн жагсаалт зэрэг болно.

3.4. Давхар даатгалын жилийн төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгана:

3.4.1. Тухайн даатгалын компанийн хүлээж чадах нийт эрсдлийн хэмжээг давхар даатгалын стратеги төлөвлөгөөнд заасан аргачлалын дагуу тодорхойлсон байх;

3.4.2. Давхар даатгуулах даатгалын хэлбэрүүд;

3.4.3. Тухайн онд харьцаж ажиллах давхар даатгагч, давхар даатгалын зуучлагч нарын жагсаалт;

3.4.4. Давхар даатгалын хяналт, тайлагнал, дотоод хяналтын талаар авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа (шинээр бий болгох бүтэц, зохион байгуулалт, тайлан гаргалт, үүнтэй холбоотой хэлэлцүүлэг хийх журам гэх мэт);

3.4.5. Өөрт үлдээх эрсдэлийн хязгаар (даатгалын хэлбэр бүрээр);

3.4.6. Энэ журмын 3.4.3-д заасан жагсаалтад дурдсан давхар даатгагчдад даатгуулах хэмжээ, хязгаар;

3.4.7. Гэрээт давхар даатгалд хамруулах даатгалын хэлбэр, хэмжээ;

3.4.8. Факультатив давхар даатгалд хамрагдах даатгалын хэлбэр, хэмжээ зэрэг болно.

3.5. Даатгагч нь даатгалын эрсдэл, тохиолдол тус бүрээр хязгаар тогтоож болох ба эдгээрийг даатгалын эрсдэлийн үнэлгээ, давхар даатгалын зардал дээр үндэслэн тооцно. Даатгагч нь өөрт үлдээх эрсдэлийн хэмжээнд тохирох хэмжээний хөрөнгийн чадвартай байх шаардлагатай.

3.6. Даатгалын компани нь давхар даатгагчид шилжүүлэх эрсдэлийн хэмжээг тодорхойлохдоо давхар даатгагч бүрийн гэрээний үүргээ биелүүлэх чадварыг үнэлж үзэх ба даатгалын эрсдэлээ тархаан байршуулах зарчмыг баримтална.

3.7. Тодорхой нэг даатгалын зүйлийн давхар даатгалын гэрээний нөхцөл нь анхны даатгалын гэрээний нөхцөлтэй тохирсон байна.

3.8. Даатгалын компани нь давхар даатгалын дотоод хяналтын нэгжтэй байна.

3.9. Даатгалын компани энэ журмын 3.2-т заасан, компанийн ТУЗ эсвэл түүнтэй адил эрх бүхий этгээдээр батлуулсан төлөвлөгөөг Санхүүгийн зохицуулах хороо (цаашид Хороо гэх)-нд ирүүлэн батлуулах бөгөөд журмын 3.4-т заасан төлөвлөгөөг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор Хороонд шинээр ирүүлэн, батлуулна.

3.10. Хороо энэ журмын 3 дугаар хэсэгт заасан зүйлүүдийг бүрэн гүйцэд тусгасан, тэдгээр нь үнэн зөв, бодитой гэж үзвэл тухайн компанийн давхар даатгалын төлөвлөгөөг баталж, энэ тухай мэдэгдлийг уг төлөвлөгөө батлагдан гарснаас хойш ажлын 14 хоногийн дотор бичгээр өгнө. Хэрэв Хороо уг төлөвлөгөөг шаардлага хангаагүй гэж үзвэл төлөвлөгөөг, үндэслэл бүхий албан бичгийн хамт буцаана.

3.11. Төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд хүсэлтээ шинэчлэгдсэн төлөвлөгөөний хамт Хороонд хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

3.12. Даатгалын компани нь давхар даатгалын төлөвлөгөөг Хороогоор батлуулахгүйгээр гэрээний дагуу хүлээсэн үүргээ Ллойдын андеррайтерийн холбоонд багтдаг даатгагчид даатгуулж болох бөгөөд гэрээ байгуулах бүрт Хорооноос зөвшөөрөл авна.

#### ДӨРӨВ. ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, ТҮҮНИЙ БИЕЛЭЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ

4.1. Хороо нь компанийн давхар даатгалын төлөвлөгөөний биелэлтэд тавих хяналт, шалгалтыг Хорооноос баталсан хяналт шалгалт хийх журмын дагуу хийнэ.

4.2. Хороо нь давхар даатгалын асуудлаар гадаад улс орнуудын даатгалын хяналтын байгууллагатай хамтран ажиллана.

4.3. Даатгалын компани нь Даатгалын тухай хуулийн 48 дугаар зүйлд заасны дагуу давхар даатгалын төлөвлөгөөний нарийвчилсан тайланг гаргаж, жил бүрийн 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ.

4.4. Давхар даатгалын тайланд давхар даатгалын хамралт, эрсдэл, хураамж, нөхөн олговор, давхар даатгалын гэрээ хэлцэл, тэдгээрийн дугаар, давхар даатгагч болон зуучлагчийн нэрсийн жагсаалт, давхар даатгалын үйл ажиллагааны үр дүнг дэлгэрэнгүй харуулсан санхүүгийн тайлан зэргийг тодорхой тусгаж, компанийн давхар даатгалын үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналтын тайлан болон давхар даатгалын гэрээний хуулбарыг хавсаргасан байна.

4.5. Давхар даатгалын тайлангийн бодитой эсэхэд Хороо хяналт тавина. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд дараах нэмэгдэл материалыг гаргуулан авч болно:

4.5.1. Давхар даатгалын гэрээ хэлцэл, тэдгээрт оруулсан өөрчлөлтүүд;

4.5.2. Давхар даатгалын слип, ковер нотын хуулбар;

4.5.3. Өмнөх хяналт шалгалтын тайлан, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний талаарх танилцуулга, тодруулга;

4.5.4. Давхар даатгалын гэрээний үзүүлэлтүүдээр гаргасан нэгтгэл болон бусад материал.

4.6. Хороо даатгалын компанийн давхар даатгалын гэрээний нууцлалыг хадгалах, уг гэрээний талаарх мэдээллийг хуульд зааснаас бусад, эсхүл даатгагч өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд бусдад өгөхийг хориглоно.

4.7. Даатгалын компани нь давхар даатгалын гэрээ байгуулах, түүний биелэлт, давхар даатгалын нэхэмжлэл, нөхөн төлбөр, эрсдэлийн байдалд хяналт тавих үүрэг бүхий дотоод хяналтын нэгжтэй байна. Компанийн дотоод хяналтын нэгжээс улирал бүрийн эхний (хуанлийн) 7 хоногт багтаан ТУЗ эсвэл түүнтэй адил эрх бүхий этгээдэд давхар даатгалын тайланг гаргаж танилцуулна.

#### ТАВ. БУСАД

5.1. Хороо энэ журмын заалтыг зөрчсөн аливаа этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--ooOoo--